

**ХӨСӨГ ТРЕЙД ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2017 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2016 оны ээлжит хурлыг 2017 оны 4-р сарын 29-ний өдрийн 12.30 минутанд Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо, Эрчим хүчний гудамж дахь компанийн өөрийн байранд болов.

Хуралд : Д.Нямбаяр 88,867 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/  
Л.Цэгмид 51,830 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/  
Л.Мягмаржав 3,870 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/  
Д.Сугаржав 1,459 ширхэг хувьцааны саналаар /саналын хуудасаар/  
Ч.Батмөнх 25,824 ширхэг хувьцааны саналаар /итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Анхбаяр өөрийн биеэр/

Бүгд 171,850 ширхэг хувьцааг төлөөлсөн этгээд буюу нийт гаргасан 295,793 ширхэг хувьцааны 58,09 % хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүд Ч.Авдай, Д.Бямбажал болон ТУЗ-ийн гишүүн Л.Аззаяа нар өөрийн биеэр оролцов.

Хурлыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Л.Мягмаржав удирдав.

Хурлаар:

- Компанийн 2016 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
- Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах, асуудлыг тус тус хэлэлцэв.

Л.Мягмаржав: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэтуяа ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 58,09% хувьтай байгаа тул Монголын Улсын Компанийн тухай хуулийн 69.1 д заасаны дагуу хурлын ирцыг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэв.

Хурал 12.40 минутанд эхлэв.

## СОНССОН НЬ :

ТУЗ-ийн дарга Мягмаржав хуралд оролцогсодыг танилцуулав:

- Бид Хөсөг Трейд компаний 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцана. Ингээд та бүхнийг хуралдаа идэвхтэй оролцохыг хүсэж байна.

Компанийн санхүүгийн тайланг нягтлан бодогч н.Баасанжаргал танилцуулав.

Хурад оролцогчдоос асуух зүйл байна уу?

- Б.Анхбаяр (Ч.Батмөнхийн итгэлмжлэгдсэн төлөөлөгч): 12 сая гаруй төгрөгийн ашигтай ажилласан юмуу. Дансаар орж ирсэн мөнгөн дүн болон ашиг ингэж харагдаж байна.
- Баасанжаргал: Санхүүгийн тайлангаар дээр ингэж харагдаж байгаа, гэхдээ өмнөх жилүүдийн хуримтлагдсан алдагдал 119,8 сая төгрөг болсон. Яагаад гэхээр манай компанийн эзэмшлийн газрын зориулалт өөрчлөгдсөн гэдэг бичиг гэнэт ирсэн. Үүнтэй холбоотойгоор газрын төлбөр хэдэн жилийн өмнөөс эхлэн нэмэгдсэнг төлж чадаагүй. Энэ нь 90 гаруй сая төгрөг болсон. Үүнийг алдагдалдаа оруулж тооцсон.
- Б.Анхбаяр: Яагаад зардалд тооцоогүй юм бэ.
- Баасанжаргал: Өмчийн өөрчлөлтийн тайлангийн залруулгад оруулж тооцсон. Гэнэт өр болж гарч ирсэн учраас төлөгдөөгүй өр гэж үзээд санхүүгийн тайланд энд нь оруулж тооцсон. Урьд нь газар эзэмшлийн өөрчлөлт болсон гэж мэдэгдээгүй гарч ирсэн өр болно.
- Л.Аззаяа: Цалингийн зардал яагаад их өндөр гарав.
- Баасанжаргал: ТУЗ-ын гишүүдийн цалинг тогтмолжуулсанаар цалингийн зардал нэмэгдсэн.
- Баасанжаргал: 2016 оны нийт орлого 274.176.822,62 төгрөг мөнгөөр орж ирсэн.
- Б.Анхбаяр: 274 сая төгрөг орж ирсэн байна. Харин авлага хэр их байна. Зээлсэн мөнгөхөр өндөр хүүтэй вэ.
- Баасанжаргал: 29 сая төгрөгийн авлага байгаа. Хүүгүй зээл хувь хүнээс авсан.
- Б.Анхбаяр: Энд байгаа барилга байгууламж болон өрөө тасалгааг харахаар орлого их бага байна гэж харагдаад байна.
- Баасанжаргал: Хуучин захиралтай хийсэн гэрээ болон хамтран ажиллах нөхцлүүд өөр байгаа. Зарим газруудаас түрээс авч чадахгүй байгаа.
- Б.Анхбаяр: Нилээд хэдэн газруудаас түрээс авдаггүй гэж ойлгож болох уу. Яагаад энэ газруудаас түрээс авахгүй байна гэдэг анхаарал татаж байна. Гүйцэтгэх захиралд үүрэг өгөх хэрэгтэй гэж бодож байна. Орлогын задаргааг ил тод хармаар байна. Энэ хэмжээний зардал ийм том газарт гарах нь тодорхой. Орлогоо нэмэгдүүлж ашигтай ажилламаар байна.
- Л.Мягмаржав: Үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захирал танилцуулъя.
- Гүйцэтгэх захирал Д.Нямбаяр: Үйл ажиллагааны тайланг танилцуулав.
- Л.Мягмаржав: Энэ бойлурын өртөг хэр их болсон бэ. Түрээслэгч нар хэр сэтгэл ханамжтай байна. Мөн, зурагаас харахад энд нэг жижиг өрөөнд үйл ажиллагаа явуулж

байгаа татварын байгууллагын өрөөг томсгоход анхаарал хандуулж, өөрсөдтэй нь ярилцсан уу? Гол нь эдгээр байгууллагаар үйлчлүүлж байгаа хүмүүс сэтгэл ханамжтай байж, энэ төрлийн үйл ажиллагаа манай дээр удаан хугацаанд байрлаж байх хэрэгтэй байна.

- Д.Нямбаяр: Бойлурын өртөг ажлын хөлстэйгээ 56,7 сая төгрөг болсон. Цаашид нэмж хийх хэдэн зүйлс бий. Манайх шиг ийм том барилгад бол 80-120 сая төгрөгийн хооронд болох байсан. Хэмнэлт гаргаж ажилласан. Түрээслэгч нар өрөөнүүд дулаан болсонд сэтгэл ханамжтай байгаа.

Мөн дээрх жижиг өрөөнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад өөр том өрөө санал болгосон ч эндээ байна гэсэн хариу өгсөн.

- Л.Мягмаржав: Дулааны шугам сүлжээ, хангамжийн байгууллагаас ялтсан бойлур тавихгүй бол цаашид дулаанаар хангахгүй гэдэг асуудлыг удаа дараа тавигдаж байсан. Энэ асуудлыг хэмнэлт гаргаж хийж гүйцэтгэсэнд талархал илэрхийлье.
- Ч.Авдай: Сургуулиас түрээс авч байна уу. 3 давхар тэр чигтээ юу.
- Д.Нямбаяр: Сургууль түрээс төлөхгүй байгаа. Харин манай зарим засварын ажлуудад мөнгө, хөрөнгөөр туслалцаа үзүүлж ажилладаг. Хоосон өрөөнүүд байгаа. Түрээслэгч байхгүй.
- Л.Цэгмэд: Зардлын хувьд, цахилгааны мөнгө их гарч байгаа. Хаана алдагдал гараад байгааг олж тогтоох гэж ажиллаад олдоогүй. Дулаан халаагч энэ тэр залгасан зүйл олдоогүй. Сард 7 сая төгрөгийн тогны мөнгө гарч байгаа.
- Б.Анхбаяр: Үйл ажиллагааны тайлан танилцуулаад дууссан уу. Барилгаа их сайхан засаж байна, хямд төсрөөр шийдсэнг нь магтууштай. Харин түрээслэгчидтэй хийсэн гэрээ болон түрээс авдаггүй газруудтай хийх ажлын зүг чигийг тодорхой болгох хэрэгтэй байна. Менежментийн багт үүрэг болгомоор байна.
- Л.Мягмаржав: Гаргах тогтоол дээрээ үүрэг чиглэл, хариуцлагыг тодорхойлж өгөх нь зүйтэй гэж бодож байна. Мөн шинэ зүйл хийхээсээ илүү одоо байгаа зүйлсээ бэхжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Дараагийн асуудал болох Ноогдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ын гаргасан Тогтоолыг ТУЗ-ын дарга Мягмаржав уншиж танилцуулав.

- А.Ариунсайн: Ноогдол ашиг хувиарлах, хувиарлахгүй тухай шийдвэр гаргадаг эцсийн субъект нь ТУЗ байдаг. Компанийн тухай хуулийн 46.5 заасны дагуу эцсийн шийдвэрийг гаргадаг. ТУЗ уг шийдвэрийг хувьцаа эзэмшигчидийн хуралд мэдээлэх үүрэг хүлээдэг.

Тогтоолын төслийг танилцуулья.

- Б.Анхбаяр: Түрээслэгч компаниудаас түрээсийг тогтмол авдаг болох, Гэрээгүй байгаа газруудтай гэрээ байгуулах гэсэн 2 санал хэлмээр байна. Гүйцэтгэх захиралд хариуцлага тооцдог баймаар байна. Гүйцэтгэх захирал удаан хугацаанд гэрээжүүлээгүй явсанг сануулах арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзэж байна.

- Мягмаржав: Анхбаярын гаргасан саналуудыг энэ хурлаас гарах тогтоолд тусгах боломжтой. Гэхдээ Хувь нийлүүлэгчдийн хурлаас Гүйцэтгэх захиралд биш ТУЗ-д үүрэг болгож оруулья. Гүйцэтгэх захиралд сануулах эрх үүрэг нь ТУЗ-д хамаарах юм байна.
- Б.Анхбаяр : ТУЗ-ын гишүүдийг өөрчлөх үү. Өөрчлөлт хийх ёстой биз дээ.
- Ариунсайн: ТУЗ-ын гишүүдийг 3 жилээр батлаад явдаг. Компанийн дүрэмд байгаа. Таньд компанийн дүрэм өгсөн байгаа уншиж танилцаарай.

Асуух зүйл байна уу.

Байхгүй бол саналаа өгөөд хурлаа хаая.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2016 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, орлогыг нэмэгдүүлэх арга хэрэгсэлийг тодорхойлон ашигтай ажиллах, түрээслэгч нартай хийх гэрээний нөхцлүүдийг тодорхой болгох, шаардлагатай бол холбогдох албан тушаалтанд зохих хариуцлага тооцон ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 15 цаг 30 минутанд өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

/ Л.МЯГМАРЖАВ/

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

/ А.АРИУНСАЙН /